



МОНГОЛ УЛС
САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ
ТОГТООЛ

2012 оны 09 сарын 26 өдөр

Дугаар 288

Улаанбаатар хот

“Бизнес инвест девелопмент ББСБ” ХХК-ийн
хаалттай өрийн бичгийг бүртгэх тухай


Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6.1.1, Компанийн тухай хуулийн 41.1, Санхүүгийн зохицуулах хорооны 2012 оны 248 дугаар тогтоолоор батлагдсан “Банк бус санхүүгийн байгууллагаас гаргах хаалттай өрийн бичгийг бүртгэх журам”-ын 2.8 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. “Бизнес инвест девелопмент ББСБ” ХХК-ийн гаргасан 12 сарын хугацаатай 800,000,000.00 /найман зуун сая/ төгрөгийн хаалттай өрийн бичгийг бүртгэсүгэй.

2. Холбогдох хууль тогтоомж болон Хорооноос баталсан журмаар хүлээсэн үүргээ чанд мөрдөж ажиллахыг “Бизнес инвест девелопмент ББСБ” ХХК /Ц.Бат-Эрдэнэ/-д үүрэг болгосугай.

3. Хаалттай өрийн бичгийг бүртгэж, тогтоолын биелэлтэд хяналт тавьж, олон нийтэд мэдээлэхийг Ажлын алба /Х.Бум-Эрдэнэ/-нд даалгасугай.

ДАРГА



Д.БАЯРСАЙХАН

001757